

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн “Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/11/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089


Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Т.Эрдэнэтуяа

Утас: 89275858

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.




АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗГ	Засгийн газар





ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 157

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ЫН 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.


Асуудлыг □онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/18 дугаар тушаалын дагуу 288,750.0 мянган төгрөгийн лууван хураагчийг “Орхон сумын тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т шилжүүлснийг үндсэн хөрөнгийн данснаас хасаж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан тушаалын цалин, хөлсний доод нийтлэг жишгийг батлах тухай” 52 дугаар тогтоолыг үндэслэн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 53,641.1 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 27.0 хувиар өссөн байна.



Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 97.5 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



1. The first part of the document discusses the importance of maintaining accurate records of all transactions and activities. It emphasizes the need for transparency and accountability in financial reporting.

2. The second part of the document outlines the various methods used to collect and analyze data. It includes a detailed description of the sampling process and the statistical techniques employed to interpret the results.


3. The third part of the document presents the findings of the study. It shows that there is a significant correlation between the variables being studied, and it provides a clear explanation of the underlying reasons for this relationship.

4. The final part of the document offers conclusions and recommendations based on the research findings. It suggests that further studies should be conducted to explore the long-term effects of the variables and to identify potential areas for improvement.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/д	Үзүүлэлт	2024.01.01	2024.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	184,419.80	121,211,998.36
1.1.2	Дансны авлага	6,897,000.00	10,630,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	211,194.13	211,194.13
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	12,000.00	43,343.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,304,613.93	132,096,535.49
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		659,820,000.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	603,566,400.00	268,427,944.76
1.2.2	Биет бус хөрөнгө	56,253,600.00	56,253,600.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	659,820,000.00	324,681,544.76
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	667,124,613.93	456,778,080.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	130,100.00	88,738,028.54
2.1.1.2	Цалингийн өглөг	4,950,012.48	-
2.1.1.3	Татварын өр	818,021.56	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,898,134.04	88,738,028.54
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,898,134.04	88,738,028.54
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	697,957,600.00	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7			
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		409,207,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(36,731,120.11)	(41,167,548.29)
2.3.10	Өмнөх үеийн ашиг /алдагдал/	(21,312,129.04)	(36,731,120.11)
2.3.11	Тайлант үеийн /алдагдал/	(15,418,991.07)	(4,436,428.18)
2.3.12	Эздийн өмчийн дүн	661,226,479.89	368,040,051.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	667,124,613.93	456,778,080.25



2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан


Д/д	Үзүүлэлт	2024.01.01	2024.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	44,800,000.00	46,900,000.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	44,800,000.00	46,900,000.00
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого	28,631,200.00	70,898,432.04
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	88,310,191.07	122,069,860.22
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	540,000.00	165,000.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(15,418,991.07)	(4,436,428.18)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(15,418,991.07)	(4,436,428.18)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(15,418,991.07)	(4,436,428.18)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(15,418,991.07)	(4,436,428.18)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		





2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан


ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	345,003,600.00			(21,312,129.04)	323,691,470.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	345,003,600.00	-	-	(21,312,129.04)	323,691,470.96
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(15,418,991.07)	(15,418,991.07)
Өмчид гарсан өөрчлөлт	352,954,000.00				352,954,000.00
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	697,957,600.00	-	-	(36,731,120.11)	661,226,479.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-				-
Залруулсан үлдэгдэл	697,957,600.00	-	-	(36,731,120.11)	661,226,479.89
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(4,436,428.18)	(4,436,428.18)
Өмчид гарсан өөрчлөлт	(697,957,600.00)		409,207,600.00		(288,750,000.00)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	-	409,207,600.00	(41,167,548.29)	368,040,051.71



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	66,370,000.00	202,530,288.55
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	38,000,000.00	40,050,000.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Татаас, санхүүжилтийн орлого		70,723,080.00
	Бусад мөнгөн орлого	28,370,000.00	91,757,208.55
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	62,939,234.20	72,152,709.99
	Ажиллагчдад төлсөн	36,280,265.59	48,075,905.21
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	18,326,034.03	12,724,758.93
	Бараа материал худалдан авахад төлсөн	222,591.00	459,014.00
	Ашиглалтын зардалд төлсөн		440,000.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,018,700.00	2,085,000.00
	Хүүний төлбөрт төлсөн		-
	Татварын байгууллагад төлсөн	4,843,943.58	5,194,231.85
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	2,247,700.00	3,173,800.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,430,765.80	130,377,578.56
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,897,000.00	9,350,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,800,000.00	9,350,000.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	97,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,897,000.00)	(9,350,000.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,466,234.20)	121,027,578.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,650,654.00	184,419.80
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	184,419.80	121,211,998.36





2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	73,431,200.00	141,187,000.00	117,798,432.04	(23,388,567.96)	83.43%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	44,800,000.00	44,800,000.00	46,900,000.00	2,100,000.00	104.69%
	Орон нутгийн төсвөөс	м/төг	28,631,200.00	96,387,000.00	70,888,080.00	(25,498,920.00)	73.55%
3	Нийт зардал	м/төг	88,850,191.07	96,387,000.00	122,234,860.22	25,847,860.22	126.82%
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг					
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	88,850,191.07	141,187,000.00	122,234,860.22	(18,952,139.78)	86.58%
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	(15,418,991.07)	44,800,000.00	(4,436,428.18)	(49,236,428.18)	(9.90)





3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

“Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ нь төмс, хүнсний ногооны тариалалт, арчлалт, хураалтын ажлыг технологийн дагуу, хугацаанд чанартай гүйцэтгэж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжуулан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 90 дугаар тогтоолоор байгуулагдан дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Өөрийн өмчлөл, эзэмшлийн хөдөө аж ахуйн зориулалттай машин механизм, техник, тоног төхөөрөмжийг газар тариалан эрхлэгч, хадлан бэлтгэгчдэд түрээсээр ашиглуулах

- Иргэн, аж ахуйн нэгжид гэрээний дагуу хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ үзүүлэх

- Улс, орон нутгийн төсөв, дотоод, гадаадын иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт, хандив, дэмжлэг, тусламжаар газар тариалангийн салбарт нийтийн зориулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг менежментийн удирдлагаар хангах, бусдад гэрээгээр ашиглуулах

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж байна.


Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Тус байгууллагын дарга зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол дотоод хяналтын нэгж санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянадаг байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.



“Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ -ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ -ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 456,778.10 мянган төгрөгөөр буюу 31.5 хувиар буурсан байна.


Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	184.4	121,212.0	121,027.6
Авлага	7,108.2	10,841.2	3,733.0
Бараа материал	12.0	43.3	31.3
Үндсэн хөрөнгө	659,820.0	324,681.5	(335,138.5)
Нийт хөрөнгө	667,124.6	456,778.1	(210,346.5)
Өр төлбөр	5,898.1	88,738.0	82,839.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	661,226.5	368,040.1	(293,186.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	667,124.6	456,778.1	(210,346.5)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 121,212.0 мянган төгрөг болж өмнөх оноос 121,027.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 113,938.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, Шинэ хөдөө төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас иргэн болон хуулийн этгээдэд олгосон хүлэмжийн орлогын урьдчилгаа болох 88,592.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, үйл ажиллагаандаа 81,502.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 10,841.2 мянган төгрөг болж өссөн нь түрээслэгч нараас авах авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 324,681.5 мянган төгрөг болж 335,138.5 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 9,350.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/18 дугаар тушаалаар 288,750.0 мянган төгрөгийн лууван хураагчийг “Орхон сумын тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т шилжүүлэн, тайлант онд 55,738.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.



Богино хугацаат өр төлбөр 88,738.0 мянган төгрөг болж 82,839.9 мянган төгрөгөөр өссөн нь Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас иргэн болон хуулийн этгээдэд олгосон хүлэмжийн урьдчилгаа орлогыг өглөгөөр бүртгэсэн нь шалтгаалсан байна.

Эздийн өмчийн дүн 368,040.1 мянган төгрөг болж 319,356.1 мянган төгрөгөөр өсөхөд тайлант үеийн ашиг алдагдал болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж авсан нь голлон нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант оны өөрийн орлогыг 44,800.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 96,387.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөж, батлуулсан байна.

Тайлант оны гүйцэтгэлээр 117,798.4 мянган төгрөгийн орлого, 122,234.8 мянган төгрөгийн зардлыг тайлагнаж, 4,436.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл орон нутгийн санхүүжилт 96,387.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 70,888.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, тайланд онд 46,900.0 мянган төгрөгийн өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого олсон нь төлөвлөсөн 44,800.0 мянган төгрөгийн орлогыг 2,100.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд 4,436.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь тухайн тайлант оны үйл ажиллагааны орлоготой холбоотой байна.


4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ -ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.



“Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ -ын 2024 оны санхүүгийн тайланг “ЦЭСБ Аудит” ХХК-д 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 88,850.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 888.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллийг бүрэн байршуулсан байна.


4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлантай холбоотой 1 акт өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.



/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	93.9	1	93.9	100.0
Нийт дүн	1	93.9	1	93.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 409,207.6 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тус “Хөдөө, аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ын эхлэлтийн балансад эздийн өмчийн дүн байгаагүй бөгөөд тайланд онд төрийн өмчийг 409,207.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйл “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт” 21^{1.7}. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргана.” заалт, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, Оршин бай х батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Эздийн өмчийн бусад хэсгээр бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 113.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул төсөвт буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт


5.1.1 Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын нягтлан бодогч Ш.Урнаад цалин, ээлжийн амралтыг давхардуулан 113.6 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т “Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно” заасантай тус тус нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

- Албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.


5.3 Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.




6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй		Зөвлөмж		
Тус байгууллагыг анх 0.0 мянган төгрөгөөр үүсгэн байгуулсан бөгөөд тайланд онд өмчийг 409,207.6 мянган төгрөгөөр тайлагнасан байна.	1	409,207.6	-	-	1	409,207.6	1	409,207.6	-	-	-	-
Дүн	1	409,207.6	-	-	1	409,207.6	1	409,207.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч Ш.Урнаагийн 7 сарын цалин болон ээлжийн амралтыг давхардуулан олгосон байна.	1	113.6	1	113.6	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	113.6	1	113.6	-	-	-	-	-	-	-	-



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн	-	-	-	-	-	-	-	

